



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН

ХОЁРДУГААР УЛИРЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2025





Агуулга

- 01 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
- 02 АРИЛЖААЛАГДАЖ БУЙ ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 03 ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ
- 04 МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ
- 05 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл
- Хүснэгт 2. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Хүснэгт 3. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Хүснэгт 4. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл
- Хүснэгт 5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл
- Хүснэгт 6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээ
- Хүснэгт 7. Орлогын дэлгэрэнгүй тайлан

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо
- Зураг 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв
- Зураг 3. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ
- Зураг 4. Баталгаажуулалт хийсэн харилцагчийн төрөл
- Зураг 5. Нийт харилцагчдын мэдээлэл
- Зураг 6. Ашигт ажиллагаа
- Зураг 7. Зардлын бүтэц

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий танилцуулга

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)–д 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид “ВХҮҮ” гэх) бүртгэлтэй байна.


Хүснэгт 1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо	Арилжааны платформын хаяг	Үйл ажиллагааны чиглэлийн тоо
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	6210139	2017.08.01	2022.09.21	Trade.mn	5
2	“Койн Хаб” ХХК	6693326	2021.04.06	2022.09.21	Coinhub.mn	5
3	“Айдакс” ХХК	6803016	2021.12.30	2022.09.21	Idax.exchange	5
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	3645789	2021.09.23	2022.10.10	Ncx.mn	3
5	“Корэкс” ХХК	6752586	2021.09.07	2022.10.10	Corex.mn	5
6	“Икс Мета” ХХК	6784771	2021.11.18	2022.10.10	X-meta.com	5
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	6719791	2021.06.20	2022.10.10	Complex.mn	5
8	“Чойжин Алтекс” ХХК	6785123	2021.11.18	2022.10.10	Altex.mn	5
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	6671845	2021.03.04	2022.10.10	Zoos.digital	5
10	“Капекс капитал” ХХК	6792987	2021.12.07	2022.11.25	Capex.mn	3
11	“Анд дэнөүд” ХХК	6783147	2021.11.12	2022.11.25	Denode.io	5
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	6906834	2022.08.25	2023.01.13	Octagon.mn	5

Дээрх ВХҮҮ–дийн 11 нь Улаанбаатар хотод байршилтай, харин “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байршилтай байна. Түүнчлэн ВХҮҮ–дийн 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–т заасан 5 үйлчилгээг үзүүлэхээр, “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК болон “Капекс капитал” ХХК нь виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах гэсэн 3 үйлчилгээг үзүүлэхээр бүртгэл хийлгэсэн.

Арилжаалагдаж буй дотоод болон гадаад виртуал хөрөнгийн тоо

Зураг 1. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо



2025 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт ВХҮҮ дээр 603 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа бөгөөд үүнээс 37 дотоодын виртуал хөрөнгө, 566 гадаадын виртуал хөрөнгө байна. Нийт арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн 93.86%–ийг гадаадын виртуал хөрөнгө эзэлж байна.

ВХҮҮ–ийн арилжааны зохион байгуулалт

Хүснэгт 2. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)

№	Хуулийн этгээдийн нэр	2024. II	Нийт арилжаанд эзлэх хувь	2025. II	Нийт арилжаанд эзлэх хувь
1	“Койн Хаб” ХХК	40,601,274,164.42	9.87%	90,372,037,090.90	43.86%
2	“Икс Мета” ХХК	78,001,523,588.77	18.96%	53,012,334,760.00	25.73%
3	“Айдакс” ХХК	69,091,341,76.93	16.8%	39,905,241,801.00	19.36%
4	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	14,870,383,052.60	3.62%	13,432,839,621.31	6.52%
5	“Чойжин Алтекс” ХХК	203,157,566,485.13	49.39%	5,376,678,606.62	2.61%
6	“Анд дэнөүд” ХХК	423,902,311.77	0.10%	2,569,175,398.17	1.25%
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	4,772,698,750.12	1.16%	1,351,088,391.22	0.66%
8	“Корэкс” ХХК	379,265,499.03	0.09%	49,871,667.22	0.02%
9	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	–	–	95,317.40	0.00005%
10	“Зоос Дижитал Эксчейнж” ХХК	–	–	–	–
11	“Капекс капитал” ХХК	–	–	–	–
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	–	–	–	–

Хүснэгт 3. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)


№	Хуулийн этгээдийн нэр	2024. II	Нийт арилжаанд эзлэх хувь	2025. II	Нийт арилжаанд эзлэх хувь
1	“Койн Хаб” ХХК	1,222,690,001.17	13.56%	11,167,340,537.03	45.7%
2	“Айдакс” ХХК	6,168,954,230.31	68.42%	6,471,450,472.00	26.5%
3	“Икс Мета” ХХК	555,014,942.45	6.16%	5,028,407,134.00	20.59%
4	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	633,585,240.40	7.03%	1,578,085,897.63	6.5%
5	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	389,518,695.90	4.32%	152,034,663.71	0.62%
6	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	12,863,231.89	0.14%	10,696,368.40	0.04%
7	“Корэкс” ХХК	26,839,016.39	0.29%	2,414,851.76	0.01%
8	“Капекс капитал” ХХК	4,015,929.48	0.045%	552,228.68	0.002%
9	“Поверэд Эй Ди Эм” ХХК	2,318,771.16	0.026%	–	–
10	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	–	–	–	–
11	“Анд дэнүүд” ХХК	–	–	–	–
12	“Чойжин Алтекс” ХХК	–	–	–	–

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар өссөн дүнгээр гадаадын виртуал хөрөнгийн 607.2 тэрбум төгрөгийн, дотоодын виртуал хөрөнгийн 40.5 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдэж, нийт арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар буурсан байна. Мөн “Чойжин Алтекс” ХХК, “Анд Дэнүүд” ХХК дээр дотоодын виртуал хөрөнгө, “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК, “Поверэд Эй Ди Эм” ХХК дээр гадаад, дотоод виртуал хөрөнгийн арилжаа тус оны хоёрдугаар улиралд хийгдээгүй болно.



ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоодын виртуал хөрөнгө

Зураг 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв

Дотоодын виртуал хөрөнгөөс “INC, ARDX” нь хамгийн олон буюу 5 ВХҮҮ дээр, “ZESC” 4 ВХҮҮ дээр, “SPC, ADMC” нь 3 ВХҮҮ дээр, “OBOT, MONT, WPL, MNFT” нь 2 ВХҮҮ дээр үлдсэн нь зөвхөн 1 ВХҮҮ дээр тус тус арилжаалагдаж байна.



Зураг 3. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ (тэрбум төгрөг)

 2024 оны хоёрдугаар улирал 2025 оны хоёрдугаар улирал

2025 оны хоёрдугаар улиралд хийгдсэн нийт арилжаа дүн өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Нийт гадаад виртуал хөрөнгийн арилжааны 70.1 хувийг USDT, XRP, ETH, BTC, DOGE, SOL болон PEPE, харин дотоодын виртуал хөрөнгийн арилжааны 95.7 хувийг ARDX, INC, SPC гэх виртуал хөрөнгүүд тус тус бүрдүүлж байна.



Хүснэгт 4. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

№	Виртуал хөрөнгийн нэр	Анхны ханш	Бүх цаг үеийн хамгийн доод ханш	Бүх цаг үеийн хамгийн дээд ханш	2025.06.30-ны байдлаарх ханш	2025.04.01–06.30 хүртэл нийт арилжааны хэмжээ (төгрөгөөр)	Зах зээлийн үнэлгээ
1	IHC	0.30	0.03	6.94	0.14	12,138,043,560.23	18,030,859,086.62
2	ARDX	1	0.79	445.00	26.84	5,926,021,614.41	25,494,479,082.95
3	SPC	0.2	0.087	3.00	0.37	5,521,470,623.02	15,627,757,039.29
4	CHB	30	3.2	248.80	7.96	278,384,281.03	3,249,019,216.96
5	ARDM	0.039	0.005	0.18	0.02	173,727,955.58	3,605,812,125.36
6	MNFT	0.3	0.0106	49.5	0.04	135,057,178.30	3,951,849,555.92
7	ARDT	4600	2000.01	5199.00	2474.00	74,921,902.26	8,911,505,507.21
8	TRD	1.00	0.001	55.00	0.17	43,058,013.10	3,581,246,922.85
9	OBOT	114	5.053	285.00	31.48	37,853,732.72	358,399,079.61
10	URGX	1	0.0001	3.00	0.11	16,721,392.89	597,651,825.74
11	BS9	1000	880.00	2000.00	1100.00	15,518,428.89	31,887,223,567.46
12	DAXT	1ARDT= 1ARDX	16.00	55.68	27.30	12,993,630.21	933,028,551.31
13	NTC	0.5	0.04	1.00	0.4	10,696,368.40	5,348,429,773.60
14	ZESC	1.00	0.04	107.9	0.27	7,772,631.82	184,944,232.72
15	MONT	1.00	1.00	1.00	1.00	6,728,226.59	249,546,969.83
16	ELFC	0.3	0.003	0.3	0.0190	3,249,838.17	535,214,803.71
17	CRX	15	0.29	30.1	0.33	2,414,851.76	115,301,923.40
18	EAC	0.01	0.001	0.007	0.001	2,278,344.62	342,819,066.28
19	DAC	0.33	0.003	0.513	0.002	1,860,893.71	16,694,533.53
20	ICTG	130	0.01	180.00	20.00	1,175,180.86	2,548,703,192.06
21	MSC	0.25	0.0011	0.35	0.16	385,329.81	527,006,401.82
22	WPL	1	0.006	1.4297	0.11	318,469.27	428,482,203.06
23	DC	1.20	0.14	4.00	0.09	121,439.52	41,125,810.80

24	CPX	0.25	0.0004	0.5004	0.0074	117,303.13	53,547,891.56
25	MOZO	0.3	0.0004	0.539	0.04	49,595.75	222,546,995.41
26	BID	0.4	0.0001	0.79	0.06	21,621.38	161,299,652.95
27	ADMC	1	0.01	1.49	0.05	19,746.49	1,477,597,638.37
28	CARE	0.15	0.0001	0.15	0.003	0.00	7,187,725.56
29	IIT	3.00	0.013	3.99	0.01	0.00	1,952,593.57
30	BDC	70	0.0492	127.95	19.9	0.00	3,360,297.97
31	BES	0.14	0.02	199.92	0.02	0.00	699,826.50
32	CAEL	2.85	0.013	3.99	0.08	0.00	79,349,529.85
33	CAMEL	0.2	0.0012	0.9996	0.04	0.00	16,811,774,065.3
34	GER	0.1	0.0001	0.1	0.03	0.00	126,459,073.64
35	MGLC	0.89	0.011	4.99	0.01	0.00	70,129,135.01
36	MNDT	1.00	1.00	1.00	1.00	0.00	1,649,142.44
37	ZOOS	1.00	0.55	0.55	0.55	0.00	133,446,223.6

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар арилжаалагдаж буй дотоодын 37 виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 145.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурсан байна. (Зах зээлийн үнэлгээг тооцохдоо жигнэсэн дундаж ханшаар тооцоолсон болно.)

Мөн тус улиралд нийт арилжааны 96.6 хувийг эзэлж буй (IHC, ARDX, SPC) гэх дотоодын 3 виртуал хөрөнгө дээр өдөрт дунджаар 262.1 сая төгрөг, үлдсэн 3.4 хувийг бүрдүүлж буй дотоодын 34 виртуал хөрөнгө дээр өдөрт дунджаар 9.1 сая төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.


Харилцагчийн мэдээлэл

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт ВХҮҮ дээр давхардсан тоогоор нийт 694,209 харилцагч бүртгэлтэй бөгөөд өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт 5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Бүртгэлтэй харилцагч	Батгалгаажуулалт хийсэн харилцагч	Идэвхитэй арилжаа хийдэг харилцагч
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	192,640	87,337	543
2	“Койн Хаб” ХХК	122,318	122,318	10,310
3	“Айдакс” ХХК	199,124	177,205	2,801
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	13,697	4,981	9
5	“Корэкс” ХХК	30,558	30,558	8
6	“Икс Мета” ХХК	13,742	13,742	1,324
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	68,884	53,726	192
8	“Чойжин Алтекс” ХХК	538	538	22
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	2,228	1,183	0
10	“Капекс капитал” ХХК	32,912	16,305	17
11	“Анд дэнөүд” ХХК	759	759	13
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	16,809	2,272	0
Нийт		694,209	510,924	15,239


Зураг 4. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал:



Насны бүлгээр




Хүйсээр




Нийт баталгаажуулалт хийсэн харилцагчийн 83 хувийг 16–45 насны харилцагчид эзэлж байна.

Зураг 5. Нийт харилцагчдын мэдээлэл



Нийт бүртгэлтэй харилцагчаас 73.6 хувь нь баталгаажуулалт хийсэн, 2.2 хувь нь идэвхтэй арилжаа хийдэг харилцагч байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл



Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ын дагуу үнэлсэн.

Хүснэгт 6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээ

ЭРСДЭЛ МАШ БАГА	ЭРСДЭЛ БАГА	ЭРСДЭЛ ДУНДАЖ	ЭРСДЭЛ ӨНДӨР
“Поверэд Эй Ди Эм” ХХК (octagon.mn)	“Чойжин Алтекс” ХХК (altex.mn)	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК (trade.mn)	–
“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК (ncx.mn)	“Корэкс” ХХК (corex.mn)	“Икс Мета” ХХК (x-meta.mn)	–
–	“Анд дэнөүд” ХХК (denode.io)	“Койн Хаб” ХХК (coinhub.mn)	–
–	“Капекс капитал” ХХК (capex.mn)	“Айдакс” ХХК (idax.exchange)	–
–	“Комплекс Дижитал Экосистем” ХХК (complex.mn)		–

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар хийсэн үнэлгээний үр дүнгээр салбарын оролцогчдын 33.3% буюу 4 ВХҮҮ нь цаашид эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тус 4 ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээг байгууллагын хэмжээ, арилжааны дүн, арилжаанд оролцогчдын төрөл зэрэг хүчин зүйлс нэмэгдүүлж байгаа буюу бизнесийн болон бүтцийн эрсдэл өндөртэй байна. “Зоос Дижитал Эксчейнж” ХХК нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг ирүүлээгүй учир үнэлгээнд ороогүй болно.

ВХҮҮ–ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтээр нийт ВХҮҮ–дийн хөрөнгийн дүн 60.1 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгө 42.3 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 17.7 тэрбум төгрөг байна. Нийт хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, эргэлтийн хөрөнгө 10.3 хувиар, эргэлтийн бус хөрөнгө 5.3 хувир тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт ВХҮҮ–дийн өр төлбөр ба эздийн өмчийн дүн 60.1 тэрбум төгрөг, өр төлбөрийн дүн 40.9 тэрбум төгрөг, эздийн өмчийн дүн 19.2 тэрбум төгрөг байна. Тайлант улиралд нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, өр төлбөр 9.96 хувиар, эздийн өмч 6.5 хувир тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Орлогын дэлгэрэнгүй тайлан (төгрөгөөр)

№	Хуулийн этгээдийн нэр	Борлуулалтын орлого	Борлуулалтын өртөг	Нийт орлогын дүн	Нийт зарлагын дүн	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	313,506,032.01	52,599,667.71	266,029,879.06	305,302,708.38	(39,272,829.32)
2	“Койн Хаб” ХХК	1,431,692,972.29	429,945,634.45	1,068,761,363.59	2,985,998,656.62	(1,917,237,293.03)
3	“Айдакс” ХХК	495,299,678.46	–	726,775,354.28	1,013,064,766.57	(286,289,412.29)
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	60,000,000.00	11,600,102.75	48,399,897.25	65,425,218.44	(17,025,321.19)
5	“Корэкс” ХХК	9,465,725.37	56,864,242.85	5,169,555.59	430,764,992.95	(425,595,922.95)
6	“Икс Мета” ХХК	123,390,226.95	–	397,478,728.31	517,893,300.90	(120,414,572.59)
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	750,309,785.72	–	761,901,144.10	581,225,530.50	180,675,613.60
8	“Чойжин Алтекс” ХХК	182,864,916.54	–	535,939,273.37	1,140,753,026.56	(604,813,753.19)
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	–	–	–	–	–
10	“Капекс капитал” ХХК	539,049.21	–	1,239,338.12	94,766,237.43	(93,526,899.31)
11	“Анд дэнөүд” ХХК	108,724,295.06	54,006,629.22	54,767,008.02	344,105,390.47	(289,338,382.45)
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	146,884.30	–	178,304.71	112,047,416.80	(111,869,112.09)

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт ВХҮҮ–д 3.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 0.61 тэрбум төгрөгийг борлуулалтын өртөгт зарцуулсан байна. Тухайн тайлант улиралд “Комплекс Дижитал Экосистем” ХХК цэвэр ашигтай ажилласан бол бусад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч алдагдалтай ажилласан байна.




Зураг 6. Ашигт ажиллагаа



2025 оны хоёрдугаар улиралд нийт ВХҮҮ–дийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад орлогын дүн 3.8 тэрбум төгрөг, зардал 7.6 тэрбум төгрөг байна. Мөн тус онд нийт ВХҮҮ–д нь нийт 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Зураг 7. Зардлын бүтэц



Нийт зардлын 68.7 хувь нь ерөнхий ба удирдлагын буюу цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түрээсийн зардалд, 25.1 хувь нь борлуулалт маркетингийн, 3.5 хувь нь санхүүгийн, 2.7 хувь бусад зардалд тус тус зарцуулсан байна.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



Засгийн газрын 4 байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-261674



www.frc.mn



vaspd@frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



[@FRC_of_Mongolia](https://twitter.com/FRC_of_Mongolia)